

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 4 дүгээр
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, 9.1.3, 9.1.11, 9.1.19, 21 дүгээр зүйлийн 21.7, 21.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан дүрмийг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл”-д нийтэлсний дараа мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч, тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн дарга, захирлуудад үүрэг болгосугай.

3. “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ийг хэрэгжүүлэн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Г.Эрхэмбаяр/-нд даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн 2003 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн “Сонгон шалгаруулах журам батлах тухай” 61 дүгээр тогтоол, Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн “Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын бодлого, чиглэлийг батлах тухай” 190 дүгээр тогтоол, “Журам батлах тухай” 191 дүгээр тогтоол, 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын бодлого, чиглэлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 112 дугаар тогтоол, 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 293 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болгосугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Д.БАССАЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

У.МЯГМАРСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ

Б.АМАРСАНАА

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ АЖ АХУЙН ХАРИЛЦААНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрчим хүчний тухай хуулийн 12.1-д заасан эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/ олгох, нөхцөл, шаардлага тогтоох, сонгон шалгаруулах, бүртгэх, хугацааг сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ дүрмийн зорилго оршино.

1.2. Эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон энэ дүрмээр зохицуулна.

1.3. Энэхүү дүрмийг Эрчим хүчний зохицуулах хороо /цаашид “ЭХЗХ” гэх/, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хүсэлт гаргагч хуулийн этгээд дагаж мөрдөнө.

Хоёр. Баримтлах чиглэл, суурь зарчим

2.1. Баримтлах чиглэл:

2.1.1. эрчим хүчний салбарын талаар төрөөс баримтлах бодлого, Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр (2018-2023), Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022)-тэй уялдсан байх нь тусгай зөвшөөрлийн зохицуулалтын тулгуур асуудал байна.

2.1.2. эрчим хүчний салбарын үр ашгийг сайжруулах, өртөг зардлыг бууруулах, хэрэглэгчийн үйлчилгээнд дэвшилтэт техник, технологи, ухаалаг систем нэвтрүүлэхийг дэмжинэ.

2.1.3. тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн техникийн найдвартай байдал, үр ашиг, үйлчилгээний түвшинг сайжруулах, тэдгээрийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн байна.

2.1.4. ногоон эрчим хүч буюу сэргээгдэх эх үүсвэрийг дэмжих чиглэл баримтална.

2.1.5. тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг харилцагч байгууллага, иргэдэд ил тод, нээлттэй, шуурхай болгох чиглэлд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлнэ.

2.2. Суурь зарчим:

2.2.1. хууль дээдлэх;

2.2.2. шударга ёс;

2.2.3. ил тод, шуурхай байх;

2.2.4. адил тэгш нөхцөлөөр хангах;

2.2.5. шударга өрсөлдөх боломжийг бүрдүүлэх;

Гурав. Тусгай зөвшөөрлийн өргөдөл, баримт бичиг гаргах, түүнийг шийдвэрлэх

3.1.Тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргагч хуулийн этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1, Эрчим хүчний тухай хуулийн 21.1, 21.2, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 9.2, Барилгын тухай хуулийн 48.1 дэх заалтуудын хүрээнд эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан өргөдөл, баримт бичиг болон шаардлагатай бусад материалыг бүрдүүлнэ.

3.2.Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, баримт бичгийг www.erc.gov.mn цахим хуудсаар бүртгүүлэх ба ЭХЗХ нь бүртгүүлсэн баримт бичгийг хянаж баталгаажуулна.

3.3.Тусгай зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг цахимаар баталгаажуулсны дараа тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд өргөдөл, баримт бичгийг хэвлэмэл байдлаар ЭХЗХ-нд ирүүлнэ. Хэвлэмэл материал нь эх хувиар байх ба шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байна.

3.4.Энэ дүрмийн 3.1-д заасан өргөдөл, баримт бичгийн үнэн зөв байдлыг хуулийн этгээд бүрэн хариуцна.

3.5.Эрчим хүчний тухай хуулийн 21.3-д заасны дагуу хөндлөнгийн шинжээч томилж болно.

3.6.Хуулийн этгээдийн ирүүлсэн хэвлэмэл өргөдөл, баримт бичгийг хянах явцад дараахь нөхцөл байдал илэрвэл Эрчим хүчний тухай хуулийн 21.5 дахь заалтын дагуу буцаана.

3.6.1.энэ дүрмийн 2.1, 2.2 дахь заалтад нийцээгүй;

3.6.2.энэ дүрмийн 3.1 дэх заалтад дурдсан бичиг баримтын бүрдэл дутуу, шаардлага хангаагүй;

3.7.ЭХЗХ-ны холбогдох ажилтан ирүүлсэн өргөдөл, баримт бичгийн хүрээнд газар дээр нь нягтлан шалгана.

3.8.ЭХЗХ нь тусгай зөвшөөрлийг Эрчим хүчний тухай хуулийн 21.7 дахь заалтыг үндэслэн хуулийн этгээдэд олгоно.

3.9.Хуулийн этгээдийн ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг шаардлага хангасан гэж үзвэл Эрчим хүчний тухай хуулийн 21.4 дэх заалтын дагуу 60 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох, эсэх шийдвэрийг гаргана.

3.10.Эрчим хүчний тухай хуулийн 21.6 дахь заалтын дагуу тусгай зөвшөөрөл олгосон буюу олгохоос татгалзсан шийдвэрийг нийтэд мэдээлнэ.

Дөрөв. Сонгон шалгаруулалт

4.1.Эрчим хүчний тухай хуулийн 21.8 дахь заалтын хүрээнд нэг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар хэд хэдэн сонирхогч хуулийн этгээд өргөдөл гаргасан тохиолдолд сонгон шалгаруулах замаар тусгай зөвшөөрлийг олгоно.

4.2.Сонгон шалгаруулалтыг ЭХЗХ-ны даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг явуулна.

4.3.Ажлын хэсэг сонгон шалгаруулалт хийхдээ өргөдөл гаргагч болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг дараахь үзүүлэлтүүдийг үндэслэн онооны системээр үнэлнэ.

4.3.1.ашиг, алдагдал (0-15 оноо)

4.3.2.өр, авлагын байдал (0-15 оноо)

4.3.3.техник, эдийн засгийн үзүүлэлтийг дээшлүүлэх талаар хийсэн болон хийхээр төлөвлөж буй ажил, түүний үр өгөөж (0-20 оноо)

4.3.4.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны өртөг, зардлын өсөлт, бууралт (0-20 оноо)

4.3.5.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай техник тоног төхөөрөмж, боловсон хүчин (0-20 оноо)

4.3.6.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны үйл ажиллагаа эрхлэх дадлага, туршлага (0-10 оноо)

4.4.Ажлын хэсэг нь энэ дүрмийн 4.3.1-4.3.6-д заасан үзүүлэлттэй холбоотой баримт, бичгийг өргөдөл гаргагчаас шаардах эрхтэй.

4.5.Ажлын хэсэг нь өргөдөл гаргагчийн үйл ажиллагааг үзүүлэлт бүрээр дүгнэн нийлбэр оноог гаргаж, хамгийн өндөр оноо авсан нэг хуулийн этгээдийг сонгон шалгаруулалтад шалгарсан гэж үзэн холбогдох дүгнэлтээ ЭХЗХ-ны хуралд танилцуулж шийдвэрлүүлнэ.

Тав. Нөхцөл, шаардлага тогтоох

5.1.ЭХЗХ нь хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгохдоо Эрчим хүчний тухай хуулийн 9.1.3 дахь заалтын дагуу тусгай зөвшөөрлийн төрөл тус бүрээр нөхцөл, шаардлагыг тогтоож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Нөхцөл, шаардлагын хавсралтаар үндсэн тоноглолын үзүүлэлт, үйлчлэх хүрээг тогтооно.

5.2.Эрчим хүчний тухай хуулийн 12.1 дэх заалтын дагуу үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч болон шинээр хүсэгч хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн төрлөөс хамааран дараахь нөхцөлүүдийг хангасан байна.

5.2.1.тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах боломжтой, санхүүгийн чадавхитай;

5.2.2.үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай тусгай зориулалтын технологийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бүрдүүлсэн;

5.2.3.мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг аюулгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах дадлага, туршлага бүхий хүний нөөцтэй;

5.2.4.эрчим хүчний хэмнэлтийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжтой;

5.2.5.үйлдвэрлэсэн, дамжуулсан, түгээсэн, хангасан эрчим хүчийг хэмжих баталгаажсан тоолуур, хэмжих хэрэгсэлтэй байх;

5.2.6.техникийн алдагдал, горим тооцоо, борлуулалт, хэрэглэгчийн үйлчилгээний программ хангамжууд, тайлагналын системтэй байх;

5.2.7.үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах багаж хэрэгсэл, машин механизмтай байх;

5.2.8.гарч болзошгүй аваар, ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, аюулгүйн нөөцийг бүрдүүлсэн байх;

5.2.9.байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөртэй байх, тэдгээрийг хугацаанд нь хэрэгжүүлэх;

5.2.10.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангасан, эрүүл, аюулгүй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх;

5.2.11.цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл олгоход цахилгаан эрчим хүчний түгээлт жилд 10 сая кВт.ц-аас багагүй, цахилгаан түгээх сүлжээ үүсгэж өмчлөлдөө бүртгэсэн;

5.2.12.дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл олгоход дулааны эрчим хүчний хэрэглэгчдийн тооцоот ачаалал 10 Гкал/ц-аас багагүй, дулаан түгээх сүлжээ үүсгэж өмчлөлдөө бүртгэж авсан;

5.3.Тусгай зөвшөөрлийн шаардлагыг төрөл тус бүрээр энэ дүрмийн хавсралтын дагуу тогтооно.

5.4.Нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, Эрчим хүчний тухай хуулийн 12.1.1-12.1.10, 12.1.12 дахь заалтад заасан тусгай зөвшөөрлийн шаардлагын

хүрээнд мөрдөж ажиллах зорилтыг хяналт шалгалтын тайлан, үйл ажиллагааны доголдож байгаа үзүүлэлтүүдийг харгалзан жил бүр тогтоож болно.

5.5.ЭХЗХ нь олон төрлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн шаардлагын зорилтыг үндсэн үйл ажиллагааны хүрээнд тогтооно. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн онцлогоос хамааруулан шаардлагын зорилтыг нэгтгэн тогтоож болно.

Зургаа. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтийг тайлагнах, дүгнэх

6.1.Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл эзэмшигч дараа жилийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч дараа жилийн 2 дугаар сарын 20-ны өдрийн дотор нөхцөл, шаардлагын биелэлтийг цахим системээр тайлагнах бөгөөд мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.

6.2.Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын тухайн оны зорилтын биелэлтийг жил бүрийн 4 дүгээр сард багтаан ЭХЗХ-ны хурлаар хэлэлцэн дүгнэнэ.

6.3.Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын тухайн оны зорилтыг энэ дүрмийн 6.1-д заасан хугацаанд тайлагнаагүй тохиолдолд биелэлтийг “Хангалтгүй” үнэлгээтэй дүгнэнэ.

6.4.Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын тухайн оны хэрэгжилтийг дүгнэхдээ үзүүлэлт бүрийн дунджаар дүгнэх бөгөөд тогтоосон хугацаа нь дуусаагүй шаардлагын заалтыг хасаж тооцно.

6.5.Эрчим хүчний тухай хуулийн 12.1.1-12.1.10, 12.1.12-д заасан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын тухайн оны зорилтын биелэлтийг дүгнэхдээ техникийн болон санхүүгийн үйл ажиллагааны үндсэн хүчин зүйлийн бодит өөрчлөлт, ЭХЗХ-ны тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг харгалзан үзнэ.

6.6.Нөхцөл, шаардлагын тухайн оны зорилтын биелэлтийг энэ дүрмийн 6.8-д заасан аргачлалын дагуу үнэлж ЭХЗХ-ны хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр дүнг холбогдох шийдвэрийн хамт тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.

6.7.Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын тухайн оны зорилтын үзүүлэлтүүдийн биелэлтэд өгсөн онооны нийлбэрээр дараахь байдлаар дүгнэнэ.

Нөхцөл, шаардлагын зорилтын биелэлт (%)	Үнэлгээ
90-ээс 100 хүртэл	Хангалттай сайн
75-аас 90 хүртэл	Сайн
60-аас 75 хүртэл	Дунд
60 хүртэл	Хангалтгүй

6.8.Нөхцөл, шаардлага, тухайн оны зорилтыг дараахь аргачлалаар үнэлнэ.

6.8.1.(Д)-зорилтын тухайн үзүүлэлтийг дүгнэж гаргасан оноо гэж,
(А)-зорилтын тухайн үзүүлэлтийн авч болох дээд оноо гэж тус тус ойлгоно.

6.8.2.нөхцөл, шаардлага, тухайн оны зорилтыг тусгай зөвшөөрлийн төрлөөс хамааруулан дараахь аргачлалаар дүгнэнэ.

6.8.2.1.эрчим хүчний үйл ажиллагааг аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу осолгүй явуулах; $D=A \cdot K_0$; K_0 -ослын коэффициент (осолгүй нөхцөлд-1, осолтой үед- 0 байна);

6.8.2.2.эрчим хүчний үйл ажиллагааг аваар, сааталгүй явуулах; $D=A \cdot (1 - (K_A/D_A + K_H/D_H + K_X/D_X))$; $K_A=0.5$ -Аваарын коэффициент; $K_H=0.3$ -Нэгдүгээр зэргийн саатлын коэффициент ; $K_X=0.2$ -Хоёрдугаар зэргийн саатлын коэффициент; D_A -Аваарын давтамжийн тоо; D_H -Нэгдүгээр зэргийн саатлын давтамжийн тоо; D_X -Хоёрдугаар зэргийн саатлын давтамжийн тоо;

6.8.2.3.гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах, шаардлагатай нөхцөл байдал үүссэн үед мөрдөж ажиллах; $D=A*(\Gamma_1+\Gamma_2)$; Γ_1 -Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулсан бол-0.6; Γ_2 -Гамшиг, эмзэг байдал, эрсдэлийг бууруулах чиглэлээр ажил гүйцэтгэж тайлагнасан бол 0.4;

6.8.2.4.компанийн дунд болон урт хугацааны стратегийг тодорхойлсон баримт, бичгүүдийг сайжруулж, мөрдөж ажиллах; Техникийн бодлого, Хүний нөөцийн бодлого, Санхүү, эдийн засгийн бодлого; $D=A*(B_T+B_{ХН}+B_C)$; B_T -Техникийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллаж байгаа бол-0.4, боловсруулан баталж, мөрдөж ажиллаагүй бол-0.2, боловсруулаагүй бол-0; $B_{ХН}$ -Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллаж байгаа бол-0.3, баталж, мөрдөж ажиллаагүй бол-0.15, боловсруулаагүй бол-0; B_C -Санхүү, эдийн засгийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллаж байгаа бол-0.3, боловсруулан баталж, мөрдөж ажиллаагүй бол-0.15 боловсруулаагүй бол-0;

6.8.2.5.эрчим хүчний аудитын зөвлөмжийн дагуу эрчим хүч хэмнэх бодлогын баримт бичиг (хөтөлбөр)-ийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гаргах, биелэлтийг хангаж тайлагнах; $D=A*(B_X+T_H+B_B+B_D)$; B_X -Эрчим хүч хэмнэх бодлогын баримт бичиг (хөтөлбөр)-ийг боловсруулсан бол-0.3, хангалтгүй боловсруулсан бол-0.15, боловсруулаагүй бол-0; T_H -нарийвчилсан төлөвлөгөөг шалгуур үзүүлэлт хүрэх үр дүнгээр төлөвлөн батлуулсан бол-0.15, батлуулаагүй бол-0; B_B -Эрчим хүч хэмнэх бодлогын баримт бичиг (хөтөлбөр)-ийн биелэлтийг загвар маягтын дагуу дүгнэсэн бол-0.15, дүгнээгүй бол-0; B_D -хэмнэлтийн тайланд хэрэгжүүлсэн арга хэмжээ хүрсэн үр дүнг тоон үзүүлэлтээр гаргаж биелэлтийг дүгнэсэн бол-0.4, арга хэмжээг биелүүлсэн боловч тоон үзүүлэлтээр дүгнээгүй бол-0.2;

6.8.2.6.цахилгаан, дулаан дамжуулах түгээх сүлжээний хамгаалалтын зурвасыг холбогдох байгууллагаар баталгаажуулан ажиллах; $D=A(X_3+X_{33})$; X_3 -Хамгаалалтын зурвасыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан бол-0.5; баталгаажуулаагүй бол-0; X_{33} -Хамгаалалтын зурвасын зөрчлийг арилгах чиглэлээр хийсэн ажлын биелэлт-0.5;

6.8.2.7.хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг ханган ажиллах талаар ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн байх, ЭХЗХ-нд болон тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч компанид түүний үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн хэрэглэгчийн санал, гомдлыг бүрэн шийдвэрлэх; $D=A(((T_K*T_E)+(E_K*E_E)+(X_K*X_E))/100)$; T_K -ЭХЗХ-ны цахим системд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг сар бүр бүртгэж тайлан гаргаж ирүүлсэн бол-0.4, ирүүлээгүй бол-0; X_K -Хэрэглэгчийн өргөдөл гомдлын бүртгэл хяналтын тогтолцоог сайжруулан программ хангамж нэвтрүүлсэн, өргөдөл гомдлыг бууруулсан бол-0.3; E_K -ЭХЗХ-ноос ТЗЭ-тэй холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэсний дагуу-0.3; T_E -Тусгай зөвшөөрөл эзэмшигчид ирсэн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь; E_E -ЭХЗХ-нд ирсэн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь; X_E -Хэрэглэгчийн өргөдөл гомдлын хяналт, шийдвэрлэлтийн тогтолцоог сайжруулсан байдал, өргөдөл гомдлыг өмнөх оноос бууруулсан үзүүлэлтийн хувь;

6.8.2.8.хөрөнгө оруулалт, их засвар, техник, зохион байгуулалтын арга хэмжээний ажлуудыг эрэмбэлж төлөвлөн, бүрэн хийж гүйцэтгэх, томоохон үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, техник, зохион байгуулалтын арга хэмжээний ажлуудын хөрөнгө оруулалтын үр ашиг, өгөөжийг тооцож ирүүлэх; $D=A((K_T*\Gamma_X/100\%)+(K_Y*A_T/A_H))$; $K_T=0.8$ төлөвлөгөөт ажлын коэффициент, $K_Y=0.2$ Үр өгөөжийн коэффициент, Γ_X -төлөвлөгөөт ажлуудын гүйцэтгэлийн дундаж хувь, A_H -үр өгөөжийг тооцох нийт ажлын тоо, A_T -үр өгөөжийг тооцсон ажлын тоо;

6.8.2.9.MNS 5919:2008 стандартын дагуу хяналтын хэмжилт хийлгэж, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу холбогдох арга хэмжээг авсан байх; $D=A*(K_C+K_B*T_B/100\%)$; K_C -MNS5919:2008 стандартын дагуу хяналтын хэмжилт хийлгэсэн байдлын коэффициент, хэмжилт хийлгэсэн бол 0.5, хийлгээгүй бол-0; K_B -байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийн коэффициент 0.5; T_B -байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийн хувь;

6.8.2.10.худалдан авсан эрчим хүчний төлбөрийг бүрэн төвлөрүүлсэн байх; $D=A*(1-(T_H-T_T)/T_H)$; T_H - Эрчим хүчний төлбөрийн нэхэмжлэхийн нийт дүн; T_T -Эрчим хүчний төлбөрт төлсөн нийт дүн;

6.8.2.11.батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах; $D=D_{T3}+D_{Ц3}+D_{Э3}+D_{Б3}+D_{Н3}$; D_{T3} -Түлшний зардлын дүгнэгдсэн оноо; $D_{Ц3}$ -Цалингийн зардлын дүгнэгдсэн оноо; $D_{Э3}$ -Элэгдлийн зардлын дүгнэгдсэн оноо; $D_{Б3}$ -Бусад зардлын дүгнэгдсэн оноо; $D_{Н3}$ -Нийт зардлын дүгнэгдсэн оноо; $D_{T3}=A_{T3}*(1-(T3_G-T3_T)/T3_T*100%/10\%)$; $T3_G$, $T3_T$ -Түлшний зардлын гүйцэтгэл, төлөвлөгөө; $D_{Ц3}=A_{Ц3}*(1-(Ц3_G-Ц3_T)/Ц3_T*100%/10\%)$; $Ц3_G$, $Ц3_T$ -Цалингийн зардлын гүйцэтгэл, төлөвлөгөө; $D_{Э3}=A_{Э3}*(1-(Э3_G-Э3_T)/Э3_T*100%/10\%)$; $Э3_G$, $Э3_T$ - Элэгдлийн зардлын гүйцэтгэл, төлөвлөгөө; $D_{Б3}=A_{Б3}*(1-(Б3_G-Б3_T)/Б3_T*100%/10\%)$; $Б3_G$, $Б3_T$ -Бусад зардлын гүйцэтгэл, төлөвлөгөө $D_{Н3}=A_{Н3}*(1-(Н3_G-Н3_T)/Н3_T*100%/10\%)$; $Н3_G$, $Н3_T$ - Нийт зардлын зардлын гүйцэтгэл, төлөвлөгөө; $A_{T3}=T3/Н3*A*50\%$; A_{T3} -Авбал зохих түлшний зардлын оноо; $A_{Ц3}=Ц3/Н3*A*50\%$; $A_{Ц3}$ -Авбал зохих цалингийн зардлын оноо; $A_{Э3}=Э3/Н3*A*50\%$; $A_{Э3}$ - Авбал зохих элэгдлийн зардлын оноо; $A_{Б3}=Б3/Н3*A*50\%$; $A_{Б3}$ - Авбал зохих бусад зардлын оноо; $A_{Н3}=A*50\%$; $A_{Н3}$ -Авбал зохих нийт зардлын оноо;

6.8.2.12.эрчим хүчний өр, авлагыг өсгөхгүй байх, санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах; $D=D_{НА}+D_{БХӨТ}+D_{ЭХХ}$; $D_{НА}$ -Нийт авлагын дүгнэгдсэн оноо; $D_{БХӨТ}$ -Нийт богино хугацаат өр төлбөрийн дүгнэгдсэн оноо; $D_{ЭХХ}$ -Эргэлтийн хөрөнгийн харьцааны дүгнэгдсэн оноо; $D_{НА}=A_{НА}*(1-(НА_G-НА_T)/НА_T*100%/10\%)$; $НА_G$, $НА_T$ -Нийт авлагын гүйцэтгэл, төлөвлөгөө; $D_{БХӨТ}=A_{БХӨТ}*(1-(БХӨТ_G-БХӨТ_T)/БХӨТ_T*100%/10\%)$; $БХӨТ_G$, $БХӨТ_T$ - богино хугацаат өр төлбөрийн гүйцэтгэл, төлөвлөгөө; $D_{ЭХХ}=A_{ЭХХ}*(ЭХХ>1.1$ бол "1", $1.1>ЭХХ>1.05$ бол "0.75", $1.05>ЭХХ>1.0$ бол "0.5", $1.0>ЭХХ>0.95$ бол "0.25", $0.95>ЭХХ$ бол "0"); $A_{НА}=A*30\%$ -Авбал зохих нийт авлагын оноо; $A_{БХӨТ}=A*30\%$ -Авбал зохих богино хугацаат өр төлбөрийн оноо; $A_{ЭХХ}=A*40\%$ -Авбал зохих эргэлтийн хөрөнгийн харьцааны оноо;

6.8.2.13.техник, эдийн засгийн үзүүлэлтийн мэдээ, тооцоо, судалгааг батлагдсан маягтын дагуу тухай бүр хөтлөх, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүртгэлийг олон улсын стандартын дагуу хөтлөх, шаардлагатай мэдээ, тооцоо судалгааг үнэн зөв гаргаж цаг хугацаанд нь ирүүлж байх; $D=A*(З_M/Н_M)$; $З_M$ -Үнэн зөв ирүүлсэн маягтын тоо; $Н_M$ -Ирүүлбэл зохих нийт маягтын тоо;

6.8.3.эрчим хүчний барилга, байгууламж барих тусгай зөвшөөрлийн хувьд;

6.8.3.1.эрчим хүчний барилга байгууламжийг тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд барьж байгуулан, ашиглалтад оруулах; Эрчим хүчний барилга байгууламжийг тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд барьж байгуулан, ашиглалтад оруулах; Барилга угсралтын ажил эхлүүлэх зөвшөөрөлтэй бол 50 хувь; Барилга угсралтын ажил дуусаж, Улсын комиссын акт гарсан бол 50 хувиар тус тус тооцно;

6.8.3.2. “Зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, батлах дүрэм” /БНБД 11-01-98/ болон холбогдох бусад дүрэм, журмын дагуу барилга байгууламжийн зураг төслийг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлж, баталгаажуулсан хувийг ирүүлэх; Баталсан зураг төслийн нийт зургийн эзлэхүүнд ногдох хувиар тооцож 100 хүртэлх хувиар дүгнэнэ;

6.8.3.3.“Зураг төсөл, хайгуул, судалгааны ажилд улсын экспертиз хийх дүрэм” /БНБД 11-203-04/-ийн дагуу барилга байгууламжийн зураг төсөлд улсын экспертиз хийлгэсэн хувийг ирүүлэх; Магадлалын дүгнэлт гарсан зургийг төслийн зургийн нийт эзлэхүүнд ногдох хувиар тооцож 100 хүртэлх хувиар дүгнэнэ;

6.8.3.4.тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 24 сарын дотор барилга байгууламжийг заасан хугацаанд барьж ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх талаар хөрөнгө оруулагч талуудтай гэрээ эцэслэн байгуулж, баталгаажуулсан хувийг ирүүлэх; Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ, байгуулсан бол 20%, Засгийн газартай Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулсан бол 40%, Хөрөнгө оруулагч талтай Хөрөнгө оруулалтын гэрээг эцэслэн байгуулсан бол 40%; Хэрвээ зөвхөн өөрийн хэрэгцээг хангах нөхцөлд Хөрөнгө оруулалт, Санхүүжилтийн гэрээг байгуулсан эсэхийг харгалзан тус бүр 50 хувиар дүгнэнэ;

6.8.3.5.барилга байгууламжийн барилга угсралтын ажлыг хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах нөхцөл биелэгдсэнээс хойш Барилга байгууламжийн барилга угсралтын ажлыг хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах нөхцөл биелэгдсэнээс хойш холбогдох хууль журмын хүрээнд 12 сарын дотор эхлүүлсэн байх; Эх үүсвэрийг барих газрын гэрчилгээтэй нөхцөлд 10%; Барилга угсралтын ажлыг эхлүүлэх тухай Эрчим хүчний яамнаас зөвшөөрөл олгосон бол 40%; дээрх зөвшөөрлүүд бүрдсэний дараа, БУА эхлүүлсэн бол ажлын явцаас хамааруулан 50 хүртэл хувиар тус тус дүгнэнэ;

6.8.3.6.барилга байгууламжийн барилга угсралтын ажилд захиалагчийн техникийн хяналтын гэрээг байгуулж, баталгаажуулсан хувийг ирүүлэх; Эрчим хүчний яамнаас Техникийн нөхцөл олгосон бол 50 хувь, Барилга угсралтын ажилд захиалагчийн техникийн хяналт тавих эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсан бол 50 хувь;

6.8.4.диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрлийн хувьд;

6.8.4.1.хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн диспетчерийн зохицуулалт хийсэн байх; Цахилгаан эрчим хүчний хэрэглээний өсөлтийг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд ногдуулснаар тооцох ба нийт энергийн өсөлтөд хамгийн бага өртөг бүхий үйлдвэрлэгчдийн ногдох энергийн хувь нэмэгдсэн бол авбал зохих онооны 70% хүртэл; Нэг худалдан авагчтай зах зээлийг хэвийн ажиллагааг хангаж ажилласан бол авбал зохих онооны 30% хүртэл хувиар дүгнэнэ;

6.8.4.2.цахилгаан, дулааны үйлдвэрлэл, хэрэглээг тэнцвэржүүлж, хангамж, хэрэглээний дунд болон урт хугацааны төлөвлөлтийг хийх; $D=A*(T_d+T_y)$, T_d -Дунд хугацааны төлөвлөлт хийж батлуулсан бол-0.5, төлөвлөлтийг хийж батлуулаагүй бол-0 байна; T_y -Урт хугацааны төлөвлөлт хийж батлуулсан бол-0.5, төлөвлөлтийг хийж батлуулаагүй бол-0 байна;

6.8.4.3.нэгдсэн сүлжээнд зэрэгцээ ажиллахаар төлөвлөж байгаа шинэ эх үүсвэрүүдийн талаар тооцоо судалгаа хийж бодит дүгнэлт гаргаж ажиллах; $D=A*(C_t+C_d)$, C_t -Нэгдсэн сүлжээнд зэрэгцээ ажиллахаар төлөвлөж байгаа бүх шинэ эх үүсвэрүүдэд тооцоо судалгаа хийсэн бол-0.5, хийгээгүй бол-0 байна; C_d -Тооцоо судалгаанд дүгнэлт гаргасан бол-0.5, хийгээгүй бол-0 байна;

6.8.4.4.Тоолуурын нэгдсэн системийг спот зах зээлийн арилжааг чадлаар тооцохтой холбоотойгоор эх үүсвэрүүдийн тоолуурыг чадал хэмжих боломжийг бүрдүүлэх талаар техник зохион байгуулалтын арга хэмжээг авах; $D=A*(1-(T_c-T_e)/T_c)$, T_c -чадал хэмжих тоолуур суурилуулах шаардлагатай цэгийн тоо; T_e -чадал хэмжих тоолуур суурилуулсан цэгийн тоо;

6.8.4.5.эрчим хүчний системийн реле хамгаалалтын тавилын тооцоог “Нэгдсэн сүлжээний дүрэм”-ийн дагуу системийн хэмжээнд бүрэн хийж, реле хамгаалалт, автоматикийн селектив (сонгох чадвар) ажиллагааг хангах; Реле

хамгаалалтын тавилын тооцоог нэгдсэн сүлжээний дүрмийн дагуу хийсэн бол 20% хүртэл; системийн хэмжээнд реле хамгаалалтын ажиллагаанаас хамаарсан тасралт гарсан эсэх 60% хүртэл; тасралтын хугацаа, тасралтын нөлөөллөөс хамааруулан 20% хүртэл хувиар дүгнэнэ; $D=A*(P+P_T+T)$; P-Реле хамгаалалтын тавилын тооцоог нэгдсэн сүлжээний дүрмийн дагуу хийсэн бол -0.2, хийгээгүй бол-0 байна; P_T -Системийн хэмжээнд реле хамгаалалтын ажиллагаанаас хамаарсан тасралт гараагүй бол-0.6, гарсан бол-0 байна; T-Тасралтын хугацаа тасралтын нөлөөлөл байхгүй бол-0.2 байна;

6.8.4.6.нэгдсэн сүлжээний найдвартай ажиллагааг хангаж цахилгаан, дулааны горим төлөвлөлтийг жилийн ± 2 хувиас илүүгүй хазайлт дотор төлөвлөх; $D=A(C_H+C_B+D_T+D_B)*K_{HA}$; C_H -Нэгдсэн сүлжээний цахилгааны үйлдвэрлэл, хэрэглээний анхны төлөвлөгөөний гүйцэтгэл ± 2 хувиас хэтрээгүй бол-0.25, хэтэрсэн бол-0 байна; C_B -Цахилгаан үйлдвэрлэх, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөвлөлтийг ± 2 хувиас хэтрээгүй бол-0.25, хэтэрсэн бол-0 байна; D_T -Нэгдсэн сүлжээний дулааны үйлдвэрлэл, хэрэглээний төлөвлөлтийг ± 2 хувиас хэтрээгүй бол-0.25, хэтэрсэн бол-0 байна; D_B -Дулаан үйлдвэрлэх, түгээх ТЗЭ-ийн төлөвлөлтийг ± 2 хувиас хэтрээгүй бол-0.25, хэтэрсэн бол-0 байна; K_{HA} -Нэгдсэн сүлжээний найдвартай ажиллагааг хангаж ажилласан байдал (системийн хэмжээний аваар саатлыг диспетчерийн шуурхай удирдлагаар ханган өргөн цар хүрээг хамрахаас сэргийлж ажилласан байдлын коэффициент-0-1 байна;

6.8.4.7.импорт, экспортын цахилгаан эрчим хүчний төлөвлөлтөд харьцуулан дүн, шинжилгээ хийж дүгнэлт гарган ажиллах; $D= A(I_C+Э_C)$; I_C -Импортын цахилгаан эрчим хүчний төлөвлөгөө гүйцэтгэлийг жилийн ± 2 хувиас хэтрүүлэхгүй төлөвлөсөн бол-0.5, хэтэрсэн бол-0 байна; $Э_C$ -Экспортын цахилгаан эрчим хүчний төлөвлөгөө гүйцэтгэлийг жилийн ± 2 хувиас хэтрүүлэхгүй төлөвлөсөн бол-0.5, хэтэрсэн бол-0 байна;

6.8.4.8.цахилгааны зах зээлийн үйл ажиллагаанд сар бүр дүгнэлт өгч, зах зээлийн загварыг боловсронгуй болгоход тодорхой санал боловсруулан сайжруулан ажиллах; $D=A(Z_3+З_С)$; Z_3 -Цахилгааны зах зээлийн үйл ажиллагаанд дүгнэлт өгч ажилласан бол-0.5, ажиллаагүй бол-0 байна; $З_С$ -зах зээлийн загварыг боловсронгуй болгоход тодорхой санал боловсруулан ирүүлсэн-0.5, ирүүлээгүй бол-0 байна;

6.8.4.9.“Тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”-ийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчид, тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай техникийн дүгнэлтийг гарган ажиллах; $D= A(P_X+M_{T3})$; P_X -Системд гарсан томоохон хэмжээний аваар, тасралтын үеийн реле хамгаалалт, автоматикийн байгууламжийн нэгдсэн дүгнэлтийг гарган ажилласан бол-0.5, ажиллаагүй бол-0 байна; M_{T3} -Тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрэглэгч хоорондын маргаан шийдвэрлэхэд шаардлагатай техникийн дүгнэлтийг гарган ажилласан бол-0.5, ажиллаагүй бол-0 байна;

6.8.4.10.хэрэглэгчдийн түвшинд ухаалаг тоолуурын нэгдсэн мэдээллийн сан бий болгох боломжийг судлан тайлагнах; Хэрэглэгчдийн тоолуурын нэгдсэн мэдээллийн сан бий болгох боломжийг судалсан тайлан ирүүлсэн бол авбал зохих оноог бүрэн тооцно, ирүүлээгүй бүрэн хасаж тооцно;

6.8.5.цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хувьд;

6.8.5.1.диспетчерийн графикт төлөвлөгөөг биелүүлж ажиллах, холбогдох дүрэм, журмын дагуу аваар, 1 ба 2-р зэргийн саатал гаргахгүй ажиллах, үндсэн тоноглолын найдвартай ажиллагааг хангах, өмнөх оноос нэмэгдүүлэхгүй байх; Дулааны станцын хувьд $D= A((K_{YT}*0.3)+(Y_K*0.3)+K_{AC})$; Хослон үйлдвэрлэлийн станцын хувьд $D=A((Y_K*0.5)+K_{AC})$; K_{YT} -үйлдвэрлэлийн төлөвлөгөөний коэффициент; K_{YT} -горимоо "ДҮТ" ХХК-иар батлуулж төлөвлөгөөний биелэлт $\pm 2\%$ -д байвал-1, $\pm 2\%$ - $\pm 5\%$ -д байвал-0.8, $\pm 5\%$ - $\pm 10\%$ -д байвал-0.5; $\pm 10\%$ -аас дээш бол-0 байна; горимоо "ДҮТ" ХХК-иар

батлуулаагүй, төлөвлөгөөний биелэлт $\pm 2\%$ -д байвал-0.8, $\pm 2\%$ - $\pm 5\%$ -д байвал-0.4, $\pm 5\%$ - $\pm 10\%$ -д байвал-0.2; $\pm 10\%$ -аас дээш бол-0 байна; Y_K -үндсэн тоноглолын зогсолтын коэффициент; Y_{K-} үндсэн тоноглолын зогсолт өмнөх оноос хэтрээгүй бол-1, хэтэрсэн бол 0; $K_{AC}=0.4 \cdot (1 - (K_A/D_A + K_H/D_H + K_X/D_X))$, K_{AC} -аваар саатлын коэффициент; $K_A=0.5$ - Аваарын коэффициент; $K_H=0.3$ - Нэгдүгээр зэргийн саатлын коэффициент; $K_X=0.2$ -Хоёрдугаар зэргийн саатлын коэффициент; D_A - Аваарын давтамжийн тоо; D_H -Нэгдүгээр зэргийн саатлын давтамжийн тоо; D_X -Хоёрдугаар зэргийн саатлын давтамжийн тоо;

6.8.5.2.үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр ашигтай байдлыг хангах. Үүнд: дотоод хэрэгцээний цахилгааны хувь, жишмэл түлшний хувийн зарцуулалт цахилгаан, дулаанд тогтоосон зорилтын хэмжээнээс хэтрүүлэхгүй байх; $D=A(K_{ДХЦЭХ}+K_{ЖТХЗ-Ц}+K_{ЖТХЗ-Д})$, $K_{ДХЦЭХ}$ -Эх үүсвэрийн дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч өмнөх оноос буурсан буюу өмнөх оны хэмжээнд байвал-0.32, нэмэгдсэн бол-0 байна; $K_{ЖТХЗ-Ц}$ -Эх үүсвэрийн жишмэл түлшний хувийн зарцуулалт цахилгаанд өмнөх оноос буурсан буюу өмнөх оны хэмжээнд байвал-0.34, нэмэгдсэн бол-0 байна; $K_{ЖТХЗ-Д}$ -Эх үүсвэрийн жишмэл түлшний хувийн зарцуулалт дулаанд өмнөх оноос буурсан буюу өмнөх оны хэмжээнд байвал-0.34, нэмэгдсэн бол-0 байна;

6.8.5.3.диспетчерийн зохицуулалтыг мөрдөж, цахилгаан үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, стандартын шаардлага хангасан эрчим хүч үйлдвэрлэх; СЭХ-ний үйлдвэрлэлийн хувьд $D=A(K_D+K_{ЭТ})$; K_D -Эрчим хүч үйлдвэрлэх төлөвлөгөөний коэффициент; K_D -эрчим хүчний хэмжээг “ДҮТ” ХХК-иар батлуулсан бол-0.5; батлуулаагүй бол-0; $K_{ЭТ}$ -Эрчим хүч үйлдвэрлэх төлөвлөгөөний биелэлтийн коэффициент; биелэлт $\pm 2\%$ -д байвал-0.5, $\pm 2\%$ - $\pm 5\%$ -д байвал-0.3; $\pm 5\%$ - $\pm 10\%$ -д байвал-0.2; $\pm 10\%$ -аас дээш бол-0; $D=A(K_D+K_{ЭТ})$; K_D -Эрчим хүч үйлдвэрлэх төлөвлөгөөний коэффициент; K_D -эрчим хүчний хэмжээг “ДҮТ” ХХК-иар батлуулсан бол-0.5; батлуулаагүй бол-0; $K_{ЭТ}$ -Эрчим хүч үйлдвэрлэх төлөвлөгөөний биелэлтийн коэффициент; биелэлт $\pm 2\%$ -д байвал-0.5, $\pm 2\%$ - $\pm 5\%$ -д байвал-0.3; $\pm 5\%$ - $\pm 10\%$ -д байвал-0.2; $\pm 10\%$ -аас дээш бол-0;

6.8.6.орон нутгийн дулаан үйлдвэрлэх, түгээх хангах тусгай зөвшөөрлийн хувьд;

6.8.6.1.горим тооцооны дагуу түгээх сүлжээний тохируулгыг бүрэн хийх, хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан дулааны эрчим хүчээр найдвартай хангах; $D=A(K_{ГТ}+Г_K)$, $K_{ГТ}$ -горимын тооцоо хийж батлуулсан бол коэффициент-0.3, батлуулаагүй бол-0 байна; $Г_K$ -горим тооцооны дагуу тохируулгыг хийсэн бол-0.7, хийгээгүй бол-0 байна;

6.8.7.цахилгаан дамжуулах тусгай зөвшөөрлийн хувьд;

6.8.7.1.цахилгаан дамжуулах сүлжээнд гарсан тасралтын улмаас дутуу дамжуулсан цахилгааныг өмнөх оноос бууруулах; $D=A \cdot C_D$, C_D -Дутуу дамжуулсан цахилгааны хэмжээ өмнөх оноос буурсан буюу өмнөх оны түвшинд байвал-1, өмнөх оноос 20% хүртэл хувиар хэтэрсэн бол-0.5, өмнөх оноос 20%-иас дээш хэтэрсэн бол-0 байна;

6.8.7.2.дамжуулах сүлжээний реле хамгаалалт, автоматикийн байгууламжийн селектив ажиллагааг хангаж ажиллах; (ДҮТ ХХК-ийн диспетчерийн зохицуулалтын үйл ажиллагааны мэдээнд үндэслэнэ) $D=A(P_X+C_B+K_{AC})$, P_X -Цахилгаан дамжуулах сүлжээнд гарсан реле хамгаалалтын буруу ажилласан тоо өмнөх оноос буурсан бол-0.25, хэтэрсэн бол 0 байна; C_B -Цахилгаан дамжуулах сүлжээнд гарсан реле хамгаалалтын селектив бус ажиллагааны тоо өмнөх оноос буурсан бол-0.25, хэтэрсэн бол-0 байна; K_{AC} -Дамжуулах сүлжээний реле хамгаалалт автоматикийн ажиллагаанаас хамаарсан системийн хэмжээний аваар саатал гараагүй бол-0.5, гарсан бол-0 байна;

6.8.7.3. дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлдвэрлэх, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй ашиглалт үйлчилгээний гэрээг байгуулан ажиллах; (цахилгаан эрчим хүчний чанар, стандартын шаардлага хангасан байдал, хэрэглэгчийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг агуулсан байна) Ашиглалт үйлчилгээний гэрээ байгуулсан бол авбал зохих оноог бүрэн тооцно, гэрээ байгуулаагүй бол бүрэн хасаж тооцно;

6.8.8. цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хувьд;

6.8.8.1. цахилгаан эрчим хүчний хэрэглээний захиалгыг оны эхэнд баталсан төлөвлөгөөнөөс $\pm 2\%$ хувиас хэтрүүлэхгүй байх; $D = A * K_{цз}$; $K_{цз}$ - Худалдан авах цахилгааны төлөвлөгөөний коэффициент; биелэлт $\pm 2\%$ байвал-1; $\pm 2\%$ - $\pm 5\%$ байвал-0.5; $\pm 5\%$ - $\pm 10\%$ байвал-0.3; $\pm 10\%$ дээш бол-0;

6.8.8.2. ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлснээр хүрсэн үр дүн, компанийн алдагдалд хэрхэн нөлөөлсөн талаар иж бүрэн шинжилгээ хийсэн байх; $D = A * (1 - (T_{\theta} - T_c) / T_c)$, T_{θ} -Ухаалаг тоолуур суурилуулахаар төлөвлөсөн айл өрхийн тоо; T_c -Ухаалаг тоолуур сууриллуулсан айл өрхийн тоо;

6.8.8.3. хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр хангаж, цахилгаан тасалдлын индексийг өмнөх оноос бууруулах; $D = A * (T_{и1} + T_{и2} + T_{и3})$, $T_{и1}$ -Исайди- өмнөх оноос нэмэгдсэн бол-0, буурсан буюу өмнөх оны хэмжээнд байвал-0.3; $T_{и2}$ - Икайди- өмнөх оноос нэмэгдсэн бол-0, буурсан буюу өмнөх оны хэмжээнд байвал-0.3; $T_{и3}$ - Исайфи- өмнөх оноос нэмэгдсэн бол-0, буурсан буюу өмнөх оны хэмжээнд байвал-0.4;

6.8.8.4. цахилгаан түгээлтийн алдагдлыг өмнөх оны гүйцэтгэлээс бууруулах; Цахилгаан түгээлтийн алдагдлыг хувь хэмжээг өмнөх оны гүйцэтгэлээс бууруулсан буюу өмнөх оны түвшинд барьж ажилласан бол авбал зохих оноог бүрэн тооцно, нэмэгдүүлсэн бол бүрэн хасаж тооцно;

6.8.9. дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрлийн хувьд;

6.8.9.1. худалдан авах дулааны эрчим хүчийг “Диспетчерийн үндэсний төв” ХХК-иар батлуулах, стандартын шаардлагад нийцсэн дулаанаар хэрэглэгчдийг тасралтгүй, найдвартай хангах; $D = A * (K_{г} + K_{дт})$; $K_{г}$ - худалдан авах дулаан, түгээх сүлжээний горимын коэффициент; $K_{г}$ -Худалдан авах дулааны хэмжээг “ДҮТ” ХХК-иар батлуулсан бол-0.5; батлуулаагүй бол-0; $K_{дт}$ -Худалдан авах дулааны төлөвлөгөөний коэффициент; биелэлт $\pm 2\%$ -д байвал-0.5, $\pm 2\%$ - $\pm 5\%$ -д байвал-0.3; $\pm 5\%$ - $\pm 10\%$ -д байвал-0.2; $\pm 10\%$ -аас дээш бол-0;

6.8.9.2. дулаан түгээх сүлжээний нэгж цахилгаан, нэгж ус, нэмэлт усны зарцуулалтыг өмнөх оны гүйцэтгэлээс хэтрүүлэхгүй байх; $D = A * (K_{цэхз} + K_{нүз} + K_{сүнз})$, $K_{цэхз}$ -Нэгж дулаанд ногдох цахилгаан эрчим хүчний зарцуулалт өмнөх оноос нэмэгдсэн бол-0, буурсан буюу өмнөх оны хэмжээнд байвал-0.3 байна; $K_{нүз}$ -Нэмэлт усны зарцуулалт өмнөх оноос нэмэгдсэн бол-0, буурсан буюу өмнөх оны хэмжээнд байвал-0.3 байна; $K_{сүнз}$ -Нэгж дулаан ногдох сүлжээний усны зарцуулалт өмнөх оноос нэмэгдсэн бол-0, буурсан буюу өмнөх оны хэмжээнд байвал-0.4 байна;

6.8.9.3. дулааны балансыг тарифын ангиллаар улирал бүр гаргаж тайлагнасан байх; $D = A * (U_{к1} + U_{к2} + U_{к3} + U_{к4})$, $U_{к1}$, $U_{к2}$, $U_{к3}$, $U_{к4}$ -Дулааны балансын коэффициент; улирал бүр дулааны балансыг үнэн зөв тооцож ирүүлсэн бол-0.25; ирүүлээгүй бол-0;

6.8.9.4. дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаандаа бусад иргэд, хуулийн этгээдийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжийг ашиглаж байгаа бол үйлчилгээний төлбөрийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу тооцож төлөх; $D = A * (1 - (Ш_{г} - Ш_{т}) / Ш_{г})$, $Ш_{г}$ -Иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжийг ашиглаж бусад хэрэглэгчийг дулаанаар хангахаар хийсэн гэрээний төлбөрийн нийт дүн; $Ш_{т}$ -

Иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжийг ашигласны төлбөрт төлсөн дүн;

6.8.9.5. тусгай зөвшөөрөлгүйгээр дулаан түгээх, хангах үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдүүд, шинээр ашиглалтад орж байгаа нийтийн зориулалттай орон сууцны дулаан түгээх, хангах гэрээг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлж байх; $D=A(1-(O_a-O_w)/O_a)$, O_a -Шинээр ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны тоо; O_w -Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд шилжүүлсэн шинээр ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны тоо;

Долоо. Гэрчилгээ олгох

7.1. Хуулийн этгээд ЭХЗХ-ны шийдвэр гарснаас 30 хоногийн дотор улсын тэмдэгтийн хураамж, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарсан үйлчилгээний төлбөр, зохицуулалтын үйлчилгээний хөлсийг ЭХЗХ-нд төлсөн байна.

7.2. Тусгай зөвшөөрөл олгосон болон олгохоос татгалзсан, хугацааг нь сунгасан, тусгай зөвшөөрлийг шинэчилсэн, нөхөн олгосон тухай мэдээлэл Тусгай зөвшөөрлийн цахим системд бүртгэгдэж, тухай бүр мэдээлнэ.

7.3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг гэсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн, ашиглах боломжгүй шалтгаанаар нөхөн олгуулах хүсэлт гаргасан бол нотлох баримтыг үндэслэн ЭХЗХ-ны даргын шийдвэрээр гэрчилгээг 10 хоногийн дотор нөхөн олгож тэмдэглэл хийсэн байна.

7.4. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн авахад дараахь нотлох баримтыг бүрдүүлэн ЭХЗХ-нд ирүүлнэ.

7.4.1. хүсэлт гаргасан албан бичиг

7.4.2. тусгай зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн олгох төлбөрийг ЭХЗХ-нд төлсөн баримт

7.4.3. тусгай зөвшөөрлийн гэрчилгээг гэсэн, үрэгдүүлсэн, хүчингүй болох талаар өдөр тутмын сонин, хэвлэлд зарлуулсан зар мэдээллийн баримт

7.4.4. аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрэм (нотариатаар гэрчлүүлсэн хуулбар)

7.4.5. улсын бүртгэлийн ерөнхий газрын лавлагаа

Найм. Тусгай зөвшөөрөл, нөхцөл, шаардлагад нэмэлт, өөрчлөлт оруулах

8.1. Эрчим хүчний тухай хуулийн 9.1.8, 23.1, 25.1.6 дахь заалтуудад заасан нөхцөл үүссэн, хуулийн этгээдийн оноосон нэр, дүрэм, тусгай зөвшөөрөл, нөхцөл, шаардлагад нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтээ холбогдох баримт бичгийн хамт ЭХЗХ-нд ирүүлнэ.

8.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс энэ дүрмийн 8.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ЭХЗХ нь 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

8.3. Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах баримт материалыг бүрдүүлсэн байна.

8.3.1. хүсэлт гаргасан албан бичиг;

8.3.2. тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах үндэслэл тайлбар тэдгээртэй холбоотой бусад нотлох баримтууд;

8.3.3. тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;

8.3.4.хуулийн этгээдийн өөрчлөгдөх үе болон өөрчлөгдсөний дараах үеийн дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээ (*нотариатаар батлуулсан*);

8.3.5.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг шилжүүлэх, барьцаалахтай холбоотой албан хүсэлт;

8.3.6.зээлийн болон барьцааны гэрээ;

8.4.Нөхцөл, шаардлага, түүний хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах баримт материалыг бүрдүүлсэн байна.

8.4.1.хүсэлт гаргасан албан бичиг, тайлбар, тэдгээртэй холбоотой бусад нотлох баримтууд;

8.4.2.эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.13 дахь заалтын дагуу эрчим хүчний дэд станц, шугам тоноглолыг шилжүүлэх, ашиглахтай холбоотой иргэн, хуулийн этгээд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд байгуулсан гэрээ. (*нотариатаар батлуулсан гэрээний хуулбар хувь*)

8.4.3.эрчим хүч үйлдвэрлэх, түгээх барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын акт, дүгнэлт;

8.4.4.үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн үзүүлэлт, техник, эдийн засгийн тооцоолол, техникийн нөхцөл, байршил, эзэмшлийн заагийн схем зураг, танилцуулга мэдээлэл;

Ес. Хугацааг сунгах, эсэх

9.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Эрчим хүчний тухай хуулийн 22.3 дахь заалтыг үндэслэн тусгай зөвшөөрөл сунгуулах өргөдлийг цахим системд хандаж гаргах ба шаардагдах мэдээллийг бүртгүүлнэ.

9.2.Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд нөхцөл, шаардлага, тухайн онуудын зорилтыг энэ дүрмийн 6.7 дахь заалтын дагуу үнэлж цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл боломжтой тусгай зөвшөөрлийг Эрчим хүчний тухай хуулийн 22.2 дахь заалтыг үндэслэн сунгах, эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

9.3.Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахдаа нөхцөл, шаардлагын биелэлтийг дараахь байдлаар авч үзнэ.

9.3.1.эрчим хүчний тухай хуулийн 12.1.1-12.1.10, 12.1.12 дахь заалтад заасан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтийг дүгнэхдээ нийт олгосон хугацааны дундаж дүнг авч үзнэ.

9.3.2.эрчим хүчний тухай хуулийн 12.1.11 дэх заалтад заасан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтийг дүгнэхдээ нийт олгосон хугацааны дундаж дүнг өссөн дүнтэй харьцуулж авч үзнэ.

9.4.Олгосон тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, нөхцөл, шаардлага өөрчлөгдсөн болон эрчим хүчний барилга байгууламж баригдаж дууссан талаарх мэдээллийг ЭХЗХ-ны www.erc.gov.mn цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

Арав. Түдгэлзүүлэх, сэргээх

10.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ дүрмийн 1.2-д заасан хууль тогтоомжийг зөрчсөн, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, тухайн оны зорилтыг хангалтгүй биелүүлсэн тохиолдол бүрт Эрчим хүчний тухай хуулийн 24.1 дэх заалтыг үндэслэн хугацаатай үүрэг даалгавар өгнө.

10.2.Энэ дүрмийн 10.1-д заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй бол эрчим хүчний хяналтын улсын байцаагч тусгай зөвшөөрөл эзэмшигчид зохих шийтгэл ногдуулж, Аж

ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1 дэх заалтын дагуу тусгай зөвшөөрлийг 3 хүртэл сараар түдгэлзүүлж болно.

10.3.ЭХЗХ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллана.

10.4.Энэ дүрмийн 10.2 дахь заалтын түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд ЭХЗХ-ны хурлын шийдвэрээр сэргээнэ.

Арван нэг. Хүчингүй болгох

11.1.ЭХЗХ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1, Эрчим хүчний тухай хуулийн 24.3, 24.4 дэх заалтуудыг үндэслэн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэр гаргана.

11.2.ЭХЗХ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.2, Эрчим хүчний тухай хуулийн 24.6 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллана.

11.3.Хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсноор Эрчим хүчний тухай хуулийн 24.5 дахь заалтыг биелүүлнэ.

Арван хоёр. Бусад зүйл

12.1.ЭХЗХ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээллийг шинэчлэх, баяжуулах, холбогдох өөрчлөлтийг хийх, мэдээллийн сангийн тасралтгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллана.

12.2.Тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгохтой холбоотой маргааныг Эрчим хүчний тухай хуулийн 6.1.6 дахь заалтын дагуу эрчим хүчний асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллага хянаж дүгнэлт гаргана.

12.3.Энэхүү дүрмийг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хууль, ЭХЗХ-ны хөдөлмөрийн дотоод журам болон бусад хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага ногдуулна.

-----oOo-----

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ШААРДЛАГА

1. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт
1	Эрчим хүчний барилга байгууламжийг тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд барьж байгуулан, ашиглалтад оруулах;
2	“Зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, батлах дүрэм” /БНБД 11-01-98/ болон холбогдох бусад дүрэм, журмын дагуу барилга байгууламжийн зураг төслийг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлж, баталгаажуулсан хувийг ирүүлэх;
3	“Зураг төсөл, хайгуул, судалгааны ажилд улсын экспертиз хийх дүрэм” /БНБД 11-203-04/-ийн дагуу барилга байгууламжийн зураг төсөлд улсын экспертиз хийлгэсэн хувийг ирүүлэх;
4	Тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 24 сарын дотор барилга байгууламжийг заасан хугацаанд барьж ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх талаар хөрөнгө оруулагч талуудтай гэрээ эцэслэн байгуулж, баталгаажуулсан хувийг ирүүлэх;
5	Барилга байгууламжийн барилга угсралтын ажлыг хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах нөхцөл биелэгдсэнээс хойш холбогдох хууль журмын хүрээнд 12 сарын дотор эхлүүлсэн байх;
6	Барилга байгууламжийн барилга угсралтын ажилд захиалагчийн техникийн хяналт хийлгэх гэрээ байгуулж, баталгаажуулсан хувийг ирүүлэх;
Дүн	

2. Цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, стандартын шаардлага хангасан эрчим хүч үйлдвэрлэх;	
2	Цахилгаан, дулаан үйлдвэрлэх үйл ажиллагааг техник, технологийн шаардлага, хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн найдвартай, үр ашигтай явуулах;	
3	Цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн технологийн процессыг холбогдох норм, стандартын дагуу аюулгүй явуулж, осол, аваар, сааталгүй ажиллах;	
4	Эрчим хүчний эх үүсгүүрээс байгаль орчинд хаях бохирдлыг холбогдох стандартаар тогтоосон хэмжээнд байлгах;	
5	Үйлдвэрлэлийн барилга болон далангийн ашиглалт, аюулгүй байдал, усан сангийн ашиглалт, хамгаалалт, усны түвшин, голын урсац зэргийг багтаасан хяналт-шинжилгээний төлөвлөгөө, хөтөлбөр гаргаж, холбогдох байгууллагаар батлуулах (УЦС-ын хувьд);	
6	Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах;	
7	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

3. Дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Дулааны үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, стандартын шаардлага хангасан дулааны эрчим хүч үйлдвэрлэх	
2	Дулаан үйлдвэрлэх үйл ажиллагааг техник, технологийн шаардлага, хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн найдвартай, үр ашигтай явуулах;	
3	Дулааны үйлдвэрлэлийн технологийн процессыг холбогдох норм, стандартын дагуу аюулгүй явуулж, осол, аваар, сааталгүй ажиллах;	
4	Эрчим хүчний эх үүсгүүрээс байгаль орчинд хаях бохирдлыг холбогдох стандартаар тогтоосон хэмжээнд байлгах;	
5	Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах;	
6	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

4. Цахилгаан дамжуулах тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Цахилгаан дамжуулах сүлжээний аюулгүй, найдвартай ажиллагааг хангаж, осол, аваар, сааталгүй ажиллах;	
2	Цахилгаан дамжуулах үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах;	
3	Цахилгаан дамжуулах сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй хийж түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах;	
4	Цахилгаан дамжуулах сүлжээнд холбогдсон түгээх сүлжээ болон хэрэглэгчдийг стандартын болон нэгдсэн сүлжээний дүрэмд заасан шаардлага хангасан цахилгаанаар хангах;	
5	Цахилгаан дамжуулах сүлжээний техникийн алдагдлыг дэд станц, шугам бүрээр, батлагдсан аргачлал болон тооцооны программ хангамжаар улирал, жилээр тооцоолох, алдагдлыг нэмэгдүүлэхгүй, зохистой түвшинд байлгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;	
6	Цахилгаан дамжуулах сүлжээг өргөтгөх хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй байх, шаардлагатай мэдээллээр хангах;	
7	Цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын зурвасын хэвийн байдлыг хангахад тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран хангах;	
8	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

5. Дулаан дамжуулах тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Дулаан дамжуулах сүлжээний аюулгүй, найдвартай ажиллагааг хангаж, осол, аваар, сааталгүй ажиллах;	
2	Дулаан дамжуулах үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах;	
3	Дулаан дамжуулах сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй хийж түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах;	
4	Дулаан дамжуулах сүлжээнд холбогдсон түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан дулаанаар хангах;	
5	Дулаан дамжуулах сүлжээний нэгж усны зарцуулалт техникийн алдагдлыг насос станц, магистраль шугам бүрээр, батлагдсан аргачлал болон тооцооны программ хангамжаар улирал, жилээр тооцоолох, нэгж усны зарцуулалтыг нэмэгдүүлэхгүй, зохистой түвшинд байлгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;	
6	Дулаан дамжуулах сүлжээний найдвартай ажиллагааг хангах, нэмэлт усны алдагдлыг бууруулах үүднээс дамжуулах сүлжээний оновчтой горим, схемийг тогтоох;	
7	Дулаан дамжуулах сүлжээг өргөтгөх хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй байх, шаардлагатай мэдээллээр хангах;	
8	Дулаан дамжуулах шугамын хамгаалалтын зурвасын хэвийн байдлыг хангахад тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах;	
9	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
	Дүн	

6. Цахилгаан түгээх тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Цахилгаан түгээх сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, осол, аваар, сааталгүй ажиллах;	
2	Цахилгаан түгээх сүлжээний техникийн алдагдлыг дэд станц, шугам бүрээр, батлагдсан аргачлал болон тооцооны программ хангамжаар улирал, жилээр тооцоолох, алдагдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлж, түгээлтийн алдагдлыг бууруулах;	
3	Цахилгаан түгээх сүлжээний үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах;	
4	Цахилгаан түгээх сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй хийж түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах;	
5	Цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан цахилгаанаар хангах;	

6	Цахилгаан түгээх сүлжээний найдвартай ажиллагааг хангах, техникийн алдагдлыг бууруулах үүднээс түгээх сүлжээний оновчтой горим, схемийг тогтоох, түгээх сүлжээнд гарч болох аваар, саатал, тасралт зэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, аваарын үед ажиллах горимыг боловсруулж мөрдөх;	
7	Цахилгаан түгээх сүлжээг өргөтгөх хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй байх, шаардлагатай мэдээллээр хангах;	
8	Цахилгаан түгээх сүлжээний хамгаалалтын зурвасын хэвийн байдлыг хангах зорилгоор иргэд, хуулийн этгээдэд шаардлага, хяналт тавих;	
9	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

7. Дулаан түгээх тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Дулаан түгээх сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, осол, аваар, сааталгүй ажиллах;	
2	Дулаан түгээх сүлжээний үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах;	
3	Дулаан түгээх сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй хийж түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах;	
4	Дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийг чанарын шаардлага хангасан дулаанаар хангах;	
5	Дулаан түгээх сүлжээний найдвартай ажиллагааг хангах, алдагдлыг бууруулах үүднээс түгээх сүлжээний оновчтой горим, схемийг тогтоох, түгээх сүлжээнд гарч болох аваар, саатал, тасралт зэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, аваарын үед ажиллах горимыг боловсруулж мөрдөх;	
6	Дулаан түгээх сүлжээг өргөтгөх хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй байх, шаардлагатай мэдээллээр хангах;	
7	Дулаан түгээх сүлжээний хамгаалалтын зурвасын хэвийн байдлыг хангах зорилгоор иргэд, хуулийн этгээдэд шаардлага, хяналт тавих;	
8	Дулаан түгээх сүлжээний нэгж усны зарцуулалт, нэмэлт усны зарцуулалт, нэгж цахилгааны зарцуулалтыг норм, дүрэм, стандартын дагуу бууруулан ажиллах;	
9	Гадна агаарын хэмээс хамааруулсан дулааны эрчим хүчний хангамж, хэрэглээний тэнцлийг сар бүрээр тооцож гаргах;	
10	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

8. Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
---	------------------	-------------------

1	ЭХЗХ-ноос баталсан зах зээлийн загвар, дүрэм, журмын дагуу бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс цахилгаан худалдан авах;	
2	Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд хавсралтад заасан нутаг дэвсгэрийн хэрэглэгчдийг цахилгаанаар найдвартай хангахад хүрэлцэх хэмжээний чадал, цахилгаан авах талаар цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон Диспетчерийн үндэсний төвтэй тохиролцох;	
3	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчдэд худалдсан цахилгааны орлогоо цахилгаан нийлүүлэгчтэй байгуулсан цахилгаан худалдах, худалдан авах гэрээнд заасан харилцах дансанд төвлөрүүлэх, худалдан авсан цахилгааны төлбөрийг уг данснаас бусад иргэн, хуулийн этгээдээр дамжуулахгүйгээр цахилгаан нийлүүлэгчид шууд төлөх;	
4	Хэрэглэгчдэд цахилгаан худалдахад урьдчилсан төлбөрт болон ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлэх зарчмыг мөрдөх;	
5	Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан цахилгаан худалдах, худалдан авах гэрээг Диспетчерийн үндэсний төвд бүртгүүлж, гэрээний биелэлтийг сар бүр тэдгээртэй хамтран дүгнэх, худалдан авсан, худалдсан цахилгааны тэнцлийг хийх тоолуур хэмжүүрийн баталгаажуулалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих;	
6	Хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авах, түүнийг шийдвэрлэх;	
7	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

9. Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Энэхүү тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд өөрийн эзэмшлийн түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийг дулаанаар найдвартай хангахад хүрэлцэх хэмжээний дулаан худалдан авах талаар дулаан үйлдвэрлэх, дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон Диспетчерийн үндэсний төвтэй тохиролцох;	
2	Дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаандаа бусад иргэд, хуулийн этгээдийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжийг ашиглаж байгаа бол үйлчилгээний төлбөрийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу тооцож төлөх;	
3	Хэрэглэгчдэд худалдсан дулааны төлбөрийг тэдгээртэй байгуулсан гэрээнд заасан хугацаанд бүрэн цуглуулж авах, худалдан авсан дулааны төлбөрийг дулаан худалдах, худалдан авах гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх;	
4	Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчтэй байгуулсан дулаан худалдах, худалдан авах гэрээний биелэлтийг улирал бүр тэдгээртэй хамтран дүгнэх, худалдан авсан, худалдсан дулааны тэнцлийг хийх тоолуур хэмжүүрийн баталгаажуулалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих;	
5	Хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авах, түүнийг шийдвэрлэх;	
6	Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, дулааны эрчим хүч худалдагч, хэрэглэгч талуудын эрх, үүрэг, хоорондын гэрээний талаар болон эрчим хүчийг үр ашигтай, зүй зохистой хэрэглэх талаар олон нийтэд тогтмол мэдээлэх, сурталчлах;	

7	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

10. Эрчим хүчээр зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Эрчим хүчээр зохицуулалтгүй хангах хэрэглэгчийг ЭХЗХ-оор тогтоолгох;	
2	Хэрэглэгчид худалдах эрчим хүчний гэрээний үнийг тодорхойлж тус гэрээг ЭХЗХ-нд бүртгүүлэх;	
3	Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд ЭХЗХ-ноос тогтоосон хэрэглэгчдийг эрчим хүчээр найдвартай хангахад хүрэлцэх хэмжээний чадал, эрчим хүч авах талаар үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй тохиролцох;	
4	Худалдан авсан эрчим хүчний төлбөрийг иргэн, хуулийн этгээдээр дамжуулахгүйгээр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид шууд төлөх;	
5	Хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авах, түүнийг шийдвэрлэх;	
Дүн		

11. Цахилгаан импортлох, экспортлох тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Цахилгаан импортлох, экспортлох сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, осол, аваар, сааталгүй ажиллах;	
2	Цахилгаан импортлох, экспортлох шугам сүлжээний техникийн алдагдлыг дэд станц, шугам бүрээр, батлагдсан аргачлал болон тооцооны программ хангамжаар улирал, жилээр тооцоолох, алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээг тогтмол авах, алдагдлыг бууруулах тооцоо, судалгаа, төлөвлөгөөтэй ажилласнаар импортын алдагдлыг бууруулах;	
3	Цахилгаан импортлох, экспортлох шугам сүлжээний үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах;	
4	Цахилгаан импортлох, экспортлох шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй хийж түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах;	
5	Тусгай зөвшөөрөлд заасан үйлчлэх хүрээний хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн цахилгаанаар хангах	
6	Цахилгаан импортлох, экспортлох шугам сүлжээг өргөтгөх хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй байх, шаардлагатай мэдээллээр хангах;	
7	Цахилгаан импортлох, экспортлох шугамын хамгаалалтын зурвасын хэвийн байдлыг тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран хангах;	
8	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ЭХЗХ, Диспетчерийн үндэсний төвөөс цахилгаан импортлох нөхцөл, болзлын талаар өгсөн удирдамж, чиглэлийн дагуу цахилгаан импортлох, экспортлох гэрээ байгуулах, хэрэгжүүлэх;	

9	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээнд цахилгаан импортлох, түүнчлэн цахилгаан импортлох хугацаа, хуваарь, техникийн нөхцөлийг Диспетчерийн үндэсний төвтэй тохиролцох;	
10	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

12. Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр найдвартай хангахад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй гэрээ байгуулж, хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн шуурхай зохицуулах;	
2	Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, хэрэглээг тэнцвэржүүлж, хангамж, хэрэглээний дунд болон урт хугацааны төлөвлөлтийг хийх;	
3	Нэгдсэн сүлжээний найдвартай ажиллагааг хангах үүднээс цахилгаан дамжуулах сүлжээний горим, схемийн оновчлолыг хийх;	
4	Нэгдсэн сүлжээний найдвартай ажиллагааг хангаж цахилгаан, дулааны горим төлөвлөлтийг жилийн 2 хувиас илүүгүй хазайлт дотор төлөвлөх;	
5	Системийн аваарын нөхцөл, байдалд дүн шинжилгээ хийх, үүнтэй холбоотой ТЗЭ-ийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх;	
6	Импортын цахилгаан эрчим хүчний төлөвлөлтөд дүн, шинжилгээ хийж ажиллах;	
7	Бусад орны диспетчерийн байгууллагуудтай харилцах шуурхай ажиллагаа, техникийн нөхцөлүүдийг тусгасан заавар боловсруулж мөрдөх, зэрэгцээ ажиллагааны үед системийн аваар эсэргүүцэх автоматик болон реле хамгаалалтын горимыг зохицуулах;	
8	Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд цахилгаан, дулааны хангамжийг таслах, хязгаарлах, сэргээх төлөвлөгөөг авч хэрэгжүүлэх;	
9	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

13. Дулаан дангаар үйлдвэрлэдэг эх үүсвэртэй, орон нутгийн дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тусгай зөвшөөрлийн шаардлага

№	Шаардлагын заалт	Тухайн оны зорилт
1	Дулааны үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, стандартын шаардлага хангасан дулааны эрчим хүч үйлдвэрлэж, түгээх, хангах;	
2	Дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах үйл ажиллагаанд дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлж, үр ашгийг дээшлүүлэх;	
3	Дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах үйл ажиллагааг холбогдох дүрмийн дагуу	

	аюулгүй явуулж, осол, аваар, сааталгүй ажиллах;	
4	Дулаан түгээх сүлжээг өргөтгөх, шинэчлэх хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй байх, шаардлагатай мэдээллээр хангах	
5	Эрчим хүчний эх үүсгүүрээс байгаль орчинд хаях бохирдлыг холбогдох стандартаар тогтоосон хэмжээнд байлгах;	
6	Хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авах, түүнийг шийдвэрлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллагатай хамтран ажиллах;	
7	ЭХЗХ-ноос батлагдсан тарифт тусгагдсан зардлыг хэтрүүлэхгүй ажиллах;	
Дүн		

-----oOo-----